



БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2025 оны 03 сарын 11 өдөр

Дугаар 5/03

Номгон

Г “Чандмань-Баянхонгор” ХК-ийг Г  
өөрчлөн байгуулж, дүрмийг  
батлах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.12, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.2.3, Компаний тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.1, 62.1.4 дахь заалтыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. “Чандмань-Баянхонгор” хувьцаат компанийг “Чандмань-Баянхонгор” хязгаарлагдмал хариуцлагатай компани болгон өөрчлөн байгуулсугай.

2. “Чандмань-Баянхонгор” хязгаарлагдмал хариуцлагатай компанийн дүрмийг хавсралтаар баталсугай.

3. “Чандмань-Баянхонгор” хязгаарлагдмал хариуцлагатай компанийн төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх захирал (Б.Соронзонбаатар)-д ДААЛГАХ нь:

3.1. “Чандмань-Баянхонгор” хязгаарлагдмал хариуцлагатай компанийг улсын бүртгэлд шинэчлэн бүртгүүлж, удирдлага арга зүйгээр хангаж, үйл ажиллагааг үр дүнтэй бүтээлч байдлаар зохион байгуулж ажилласугай.

3.2. “Чандмань-Баянхонгор” хязгаарлагдмал хариуцлагатай компанийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг жил бүр аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанаар хэлэлцүүлсүгэй.

4. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцож ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Ц.Байгальмаа)-д даалгасугай.

5. Энэ тогтоол гарсантай холбоотойгоор аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2012 оны 10 дугаар сарын 11-ний өдрийн 18/3 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.


ДАРГА



Э.ЭНХБАТ

642301098

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн  
Хурлын 2025 оны 03 дугаар сарын  
11-ний өдрийн 5/03 дугаар тогтоолын  
хавсралт



**“ЧАНДМАНЬ БАЯНХОНГОР” ХЯЗГААРЛАГДМАЛ  
ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИЙ ДҮРЭМ**

**Нэг. Нийтлэг үндэслэл**

1.1.Энэхүү дүрэм нь орон нутгийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн эрх зүй байдал, үйл ажиллагааны чиглэл, удирдлагын бүтэц, тэдгээрийн эрх, үүргийг тодорхойлсон эрх зүйн үндсэн баримт бичиг мөн.

1.1.2.“Чандмань Баянхонгор” хязгаарлагдмал хариуцлагатай компани нь Компаний тухай хууль, Иргэний хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Хот суурины усан хангамж, ариутгах татуургын тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомж, эрх бүхий байгууллагаас хууль, тогтоомжинд нийцүүлэн гаргасан тогтоол шийдвэр, энэхүү дүрмийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулна.

1.1.3.Орон нутгийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани (цаашид “компани” гэх)-ийн үүсгэн байгуулагч, хувь нийлүүлэгч нь Баянхонгор аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал байна.

**Хоёр.Компаний хэлбэр, оноосон нэр, байршил тэмдэг**

2.1.Компани нь 100 хувь Орон нутгийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани бөгөөд бие даасан тайлан тэнцэлтэй, өөрийн нэрийн өмнөөс эрх эдэлж, үүрэг хүлээдэг, өөрийн тусгаарласан эд хөрөнгөтэй, ашгийн төлөө хуулийн этгээд юм.

2.1.2.Компанийн оноосон нэр нь орон нутгийн өмчит “Чандмань-Баянхонгор” хязгаарлагдмал хариуцлагатай компани, товчилсон нэр нь “Чандмань-Баянхонгор” ХХК байна.

2.1.3.Компанийн байршил нь түүний гүйцэтгэх удирдлагын байрлаж буй хаягаар тодорхойлогдоно.

Компанийн хаяг нь: Баянхонгор сумын Номгон нэгдүгээр баг, Тээвэрчдийн 3 дугаар гудамжны 304 дүгээр байр байна.

2.1.4.Компани нь өөрийн тэмдэг, бичгийн хэвлэмэл хуудас, харилцах данстай байна.

2.1.5.Тэмдэг нь компанийн албан ёсны шийдвэр, албан бичиг, гэрээ, хэлцлүүдийг баталгаажуулах зорилготой.

### **Гурав. Компанийн үндсэн зорилго, үйл ажиллагааны чиглэл хугацаа**

3.1.Компанийн үндсэн зорилго нь тухайн нутаг дэвсгэртээ хот суурины хэрэглэгчийг стандартын шаардлагад нийцсэн цэвэр усаар хангах, хэрэглээнээс гарсан бохир усыг татан зайлуулах, цэвэрлэх зориулалттай барилга байгууламжийг өмчлөх ашиглах, барилга угсаралт, дулаан үйлдвэрлэх, түгээх хангах бусад хуулиар хүлээсэн үүргээ цаг хугацаанд нь биелүүлэх, өөрийгөө бүрэн санхүүжүүлэн эдийн засгийн үр ашигтай ажиллахад оршино.

3.2.Компанийн үйл ажиллагааны үндсэн чиглэл нь холбогдох хууль тогтоомжоор олгогдсон эрх үүргийн хэмжээнд дор дурдсан чиглэлээр үйл ажиллагаа явуулна.

Үүнд:

3.1.1.Усан хангамж, ариутгах татуурга

3.1.2.Цэвэр болон бохир уснаас дээжийн шинжилгээ авах

3.1.3.Усны тоолуур баталгаажуулах, засварлах

3.1.4.Дулаан үйлдвэрлэх, дамжуулах

3.1.5.Халуун усны үйлчилгээ үзүүлэх

3.1.6.Хэрэглэгчдийн гомдол, хүсэлтийг хүлээн авах, хууль дүрмийн дагуу шийдвэрлэх, арга хэмжээ авч нийтэд мэдээллэх

3.1.7.Холбогдох хууль тогтоомж, хангагч, хэрэглэгч талуудын эрх үүрэг хоорондын гэрээний талаар болон усыг үр ашигтай, зүй зохистой хэрэглэх талаар олон нийтэд тогтмол мэдээлэл сурталчилгаа хийх

3.1.8.Хэрэглэгчдэд хүргэх үйлчилгээг сайжруулах, нэмэгдүүлэх, үйлчилгээнийхээ хүрээг тэлэх талаар бизнес төлөвлөгөө, төсөл хөтөлбөр боловсруулах, хэрэгжүүлэх

3.1.9.Компани нь дээр дурдснаас гадна хуулиар хориглоогүй бусад бизнесийн үйл ажиллагаа явуулж, орлого ашгаа нэмэгдүүлэхийн төлөө ажиллаж болох бөгөөд энэ тухай саналыг Төлөөлөн удирдах зөвлөлд тавьж шийдвэрлүүлнэ.

3.1.10.Хувь нийлүүлэгчдийн хурлаас компанийг татан буулгахаар шийдвэрлэсэн болон эрх зүйн бусад шалтгааны улмаас компани нь үйл ажиллагаагаа цаашид үргэлжлүүлэн явуулах үндэслэлгүй болсноос бусад тохиолдолд үйл ажиллагаагаа хугацаагүйгээр явуулна.

## **Дөрөв. Компанийн хөрөнгө**

4.1.Компанийн хөрөнгө нь

4.1.1.Компанийн өөрийн хөрөнгө

4.1.2.Орон нутгийн өмчөөс хууль тогтоомжийн дагуу хуваарилагдсан, шилжүүлсэн хөрөнгө

4.1.3.Үйлдвэрлэл үйлчилгээний үр дүнд бий болсон эд хөрөнгө

4.1.4.Компанийн дүрмийн сан нь орон нутгийн өмчөөс хуваарилсан хөрөнгө

4.1.5.Бусад эх үүсвэрээс бий болсон хөрөнгөөс бүрдэнэ.

## **Тав. Компанийн эрх, үүрэг**

5.1.Компанийн хэлбэрийг өөрчлөх, татан буулгах, компанийн дүрэмд өөрчлөлт оруулах асуудлыг Төлөөлөн удирдах зөвлөлөөр хэлэлцүүлэн хувь нийлүүлэгчдийн хурал буюу аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тавьж шийдвэрлүүлнэ.

5.2.Компани нь өөрийн үйл ажиллагаагаа бие даан хуулийн хүрээнд эрхлэнэ.

5.3.Компани үндсэн болон туслах үйлдвэрлэл, үйлчилгээний ажлыг хэвийн явуулах зорилгоор мэргэжил чадвар сайтай, дадлага туршлагатай боловсон хүчнийг хөдөлмөрийн гэрээгээр авч ажиллуулж, тэдний ажиллах нөхцөл, хөдөлмөрийн хөлс, урамшууллын хэмжээг тогтооно.

5.4.Компани төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, түүнчлэн олон улсын холбогдох байгууллагад гишүүнээр элсэн ашиг сонирхлоо хэрэгжүүлэхэд төлөөлөл оролцуулан хамтран ажиллах болно.

5.5.Компани нь өөрийн эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангаж, үйл ажиллагааныхаа зорилгод нийцүүлэн эзэмшиж ашиглана.

5.6.Компани нь хөдөлмөрийн гэрээгээр ажиллагсдын өмнө хуулиар хүлээсэн үүргүүдийг биелүүлнэ.

5.7.Компани нь Улсын бүртгэлийн гэрчилгээ авсан өдрөөс үйл ажиллагаа явуулна.

5.8.Гүйцэтгэх захирлын үйл ажиллагаатай холбогдон үүссэн маргааныг шүүх хянан шийдвэрлэхэд Төлөөлөн удирдах зөвлөлийн томилсон итгэмжлэгдсэн төлөөлөгч компанийг төлөөлөн оролцоно.

## **Зургаа. Компаний удирдлага**

6.1.Компанийн удирдлага дараах бүтэцтэй байна.

6.1.1.Хувь нийлүүлэгчдийн хурал

6.1.2.Төлөөлөн удирдах зөвлөл /ТУЗ/

6.1.3.Гүйцэтгэх удирдлага

## **Долоо. Хувь нийлүүлэгчдийн хурал**

7.1.Компанийн эрх барих дээд байгууллага нь хувь нийлүүлэгчдийн хурал буюу аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал бөгөөд хурлын бүрэн эрхийг хувь нийлүүлэгчдийн хурлаас томилсон Төлөөлөн удирдах зөвлөл (Цаашид ТУЗ гэх) хэрэгжүүлнэ.

7.2.Хувь нийлүүлэгчдийн хурлаар хэлэлцэх асуудлыг ТУЗ-ийн хуралдааны шийдвэрийг үндэслэн дэгийн дагуу хэлэлцэнэ.

7.3.Хувь нийлүүлэгчдийн хурлаас шийдвэрлэсэн асуудлаар тогтоол гаргана. Хурлын ирц, хэлэлцсэн асуудлын талаар тэмдэглэл хөтөлнө.

7.4.Дор дурдсан асуудлыг Хувь нийлүүлэгчдийн хурлаар хэлэлцэж шийдвэрлэнэ.

7.4.1.Компанийн дүрэм болон дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах, түүний шинэчилсэн найруулга

7.4.2.Нийлэх, нэгдэх, хуваах, тусгаарлах буюу өөрчлөх хэлбэрээр компанийг өөрчлөн байгуулах

7.4.3.Компанийн хэлбэрийг өөрчлөх

7.4.4.Компанийн татан буулгах болон татан буулгах комисс томилох

7.4.5.Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох, гишүүдийг татах, нөхөн томилох. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн нь ус хангамж, ариутгах татуурга, дулаан үйлдвэрлэх, түгээх төрийн болон хувийн хэвшилд ажилладаг буюу түүнтэй холбоотой санхүүгийн ашиг сонирхолтой байж болохгүй. Мөн холбогдох яам, зохицуулах хороо эрх бүхий байгууллагад зөвлөхөөр ажилладаг санхүүгийн ашиг сонирхолтой байж болохгүй.

### **Найм.Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэн эрх**

8.1.Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл нь 9 гишүүнтэй байна.

8.2.“Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн 5-аас доошгүй нь аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч байна. Бүрэн эрхийн хугацаа 4 жилийн хугацаатай байна”.

8.3.ТУЗ-ийн даргыг ТУЗ-ийн гишүүдийн дотроос нийт гишүүдийн олонхийн саналаар сонгоно.

8.4.ТУЗ-өөс дараах асуудлыг хэлэлцэн шийдвэрлэнэ.

8.4.1.Компанийн бүтэц, орон тоог батлах

8.4.2.Компанийн зорилтот түвшин, их засвар хөрөнгө оруулалтын төлөвлөгөө, бизнес төлөвлөгөө батлах

8.4.3.Компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан, дүгнэлтийг хэлэлцэж батлах

8.5.4.Компанийн гүйцэтгэх удирдлагийн цалинг тогтоох

8.4.5.Компанийн салбар болон төлөөлөгчийн газар байгуулах, гэрээ хэлцэл хийх, зөвшөөрөл олгох

8.4.6.Аудитын байгууллагыг сонгож, гэрээ байгуулах

8.4.7.Гүйцэтгэх удирдлагын дотоод зохион байгуулалтыг батлах

8.4.8.Компанийн гүйцэтгэх удирдлага нь нөөц сантай байж болох бөгөөд сангийн хэмжээг тогтоох.

8.4.9.Компанийн эд хөрөнгийг худалдах, эд хөрөнгийн эрхийн зах зээлийн үнийг тодорхойлох

8.4.10.Компанийн гүйцэтгэх удирдлагын сарын үр дүнг компанид мөрдөгдөж байгаа журмаар олгоно.

8.4.11.Гүйцэтгэх удирдлагын жилийн үр дүнг тогтоох

8.4.12.Компанийн хөрөнгийг барьцаалах, зээл авах эрх олгох

8.4.13.Гүйцэтгэх захирлыг томилох, чөлөөлөх, гэрээ байгуулахад санал өгөх

8.4.14.Компанийн хяналтын зөвлөлийг томилж, чөлөөлөх, түүний ажлын төлөвлөгөө тайланг хэлэлцэх

8.4.15.Хувь нийлүүлэгчдийн хурлаар хэлэлцэхээр оруулсан бусад асуудал

8.5.16.Энэхүү дүрмийн 8.3.8, 8.3.9-д заасан асуудлуудыг ТУЗ нь хувь нийлүүлэгчдийн хуралд дараа тайлагнахаар хэлэлцэн шийдвэрлэнэ.

### **Ес. Гүйцэтгэх удирдлага**

9.1.Компанийн гүйцэтгэх удирдлага нь компанийн дүрэм болон ТУЗ-тай байгуулсан гэрээний дагуу өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулна. Компанийн гүйцэтгэх удирдлага нь компанийн гүйцэтгэх захирал байна. Гүйцэтгэх захирал нь ус хангамж, ариутгах татуурга, дулаан үйлдвэрлэлийн салбарын төрийн өмчийн болон хувийн үйлдвэрийн газар, аж ахуйн нэгжид үйл ажиллагаа явуулдаг санхүүгийн ашиг сонирхолтой байж болохгүй.

9.2.Компанийн гүйцэтгэх захиралыг ТУЗ-өөс санал оруулснаар аймгийн засаг дарга томилно.

9.3.Компанийн гүйцэтгэх захирлын эрх, үүрэг

9.3.1.Компанийн эрх ашгийг дээдлэн тавьж, мэргэжил, ажлын дадлага, туршлагаа бүрэн дайчлан компанийн менежментийн бодлого боловсруулан компанийг удирдана.

9.3.2.Компанийн хөрөнгийг энэхүү дүрэм, ТУЗ-тэй байгуулсан гэрээ, хувь нийлүүлэгчдийн хурлаас олгосон эрх хэмжээний дотор эзэмшиж ашиглах.

9.3.3.Компанийн захирлын зөвлөлийг байгуулах

9.3.4.Компанийн үйл ажиллагааны тухайн жилийн зорилтот түвшин, бизнес төлөвлөгөөний төслийг боловсруулж, ТУЗ-ийн хуралд оруулж батлуулах, түүний хэрэгжилтийг зохион байгуулах

9.3.5.Хувь нийлүүлэгчдийн хурлын өмнө компанийн үйл ажиллагааг бүрэн хариуцаж, хагас, бүтэн жилийн эцэст ажлын үр дүнг тайлагнан дүгнүүлэх

9.3.6.Энэхүү дүрэм болон холбогдох хууль тогтоомж, норм, норматив, компанийн хувь нийлүүлэгчдийн хурлын шийдвэр, үүрэг даалгаврыг биелүүлэх ажлыг зохион байгуулж, гүйцэтгэлийг хангуулах

9.3.7.ТУЗ-өөс баталсан орон тоо, зохион байгуулалтын бүтцийн хүрээнд ажилтнуудын ажлын байрны тодорхойлолтыг батлах, ажилтныг ажилд томилох, тэдэнтэй хөдөлмөрийн гэрээ байгуулах, ажлаас чөлөөлөх

9.3.8.Хувь нийлүүлэгчдийн хурлын өмнө хүлээсэн үүргийг биелүүлэх. Удирдаж буй компанийн санхүү, төлбөрийн чадвар, нэр хүндийг дээшлүүлэхэд чиглэсэн бодлого, үйл ажиллагаа хэрэгжүүлж, зохион байгуулах

9.3.9.Гүйцэтгэх захирал нь ТУЗ-ийн зөвшөөрлийн үндсэн дээр зарим эрх, үүргээ итгэмжлэл гарган компанийн холбогдох албан тушаалтанд шилжүүлж болно. Ийнхүү эрхээ итгэмжлэн шилжүүлсэн нь түүнийг хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.

9.3.10.Компанийн үйл ажиллагаатай холбогдох асуудлаар тушаал гаргаж биелэлтийг хангуулах

9.3.11.Компанийн шинээр худалдан авах болон актлаж устгах, худалдах үндсэн хөрөнгө тоног төхөөрөмж, автомашин механизм, барилга байгууламжийн асуудлыг нэгтгэж хувь нийлүүлэгчдийн хуралд тавьж шийдвэрлүүлэх

9.3.12.Эрх бүхий харилцаанд компанийг төлөөлөх

9.2.13.Хуульд өөрөөр заагаагүй бол өөрийн хууль бус үйл ажиллагаанаас компанид учирсан хохирлыг хариуцах

#### **Арав. Компанийн хяналтын тогтолцоо**

10.1.Компанийн хяналтын тогтолцоо нь дараах бүтэцтэй байна. Үүнд:

10.1.1.Өмчлөгчийн хяналт

10.1.2.Хөндлөнгийн аудитор

10.2.Өмчлөгчийн хяналтыг хувь нийлүүлэгчдийн хурлаас томилогдсон Хяналтын зөвлөл /цаашид "ХЗ" гэх/ хэрэгжүүлнэ

10.3.Хяналтын зөвлөлийг 3 хүний бүрэлдэхүүнтэй ТУЗ-өөс томилох бөгөөд хийсэн ажлынхаа тайланг жилд нэгээс доошгүй удаа ТУЗ-ийн хуралд тайлагнах үүрэгтэй.

10.4.Хяналтын зөвлөлийн гишүүнд компанийн эрх бүхий албан тушаалтан байж болохгүй.

10.5.Компанийн хөндлөнгийн хяналт шалгалтыг төрийн аудитын байгууллагаас томилсон мэргэшсэн аудитын байгууллага буюу аудитороор жилд нэгээс доошгүй удаа хийлгэнэ.

10.6.Хөндлөнгийн аудитор тайланг захирлын гэрээ дүгнэх ТУЗ-ийн хурлаар хэлэлцүүлж дүгнэлт гаргана.

#### **Арван нэг. Компанийн нягтлан бодох бүртгэл, тайлан**

11.1.Компани нь Нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, Олон Улсын нягтлан бодох бүртгэлийн стандартын дагуу хөтлөн, санхүүгийн тайлан гаргаж, аудитын байгууллагаар дүгнэлт гаргуулан, хувь нийлүүлэгч болон эрх бүхий бусад этгээдэд танилцуулна. Санхүүгийн тайлангийн үнэн зөвийг компаний Гүйцэтгэх захирал, ерөнхий нягтлан нар хариуцна.

11.2.Компанийн санхүүгийн жилийн эхлэх хугацааг тухайн оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс, дуусах хугацааг мөн оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тогтооно.

#### **Арван хоёр. Компанийн санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан**

12.1.Компанийн санхүүгийн тайланд дараах зүйлийг тусгана.

12.1.1.Баланс

12.1.2.Орлого, үр дүнгийн тайлан

12.1.3.Мөнгөн гүйлгээний тайлан

12.1.4.Өмчийн өөрчлөлтийн тайлан

12.1.5.Нэмэлт тайлбар

12.1.6.Бусад

#### **Арван гурав. Компанийн бичиг баримтыг хадгалах**

13.1.Компани нь дараах бичиг баримтыг хадгална.

13.1.1.Компанийн дүрэм, дүрэмд орсон нэмэлт өөрчлөлт, компанийг байгуулах тухай үүсгэн байгуулагчдын хурлын шийдвэр, компанийн бүртгэлийн гэрчилгээ Хувь нийлүүлэгчдийн хурал, Төлөөлөн удирдах зөвлөл, Гүйцэтгэх удирдлага болон Хянан шалгах зөвлөлөөс баталсан компанийн дотоод бичиг баримт

13.1.2.Нягтлан бодох бүртгэлд тусгагдсан эд хөрөнгө болон эд хөрөнгийн эрхийг нотлох баримт бичиг

13.1.3.Хувь нийлүүлэгчдийн хурлын тэмдэглэл, шийдвэр, Гүйцэтгэх захирлын тушаал (ТУЗ-ийн хурлын тогтоол, хурлын тэмдэглэл, Захирлын зөвлөлийн хурлын тэмдэглэл, Хамт олны хурлын тэмдэглэл, Гүйцэтгэх захирлын тушаал, шийдвэр)

13.1.4.Хяналтын зөвлөлийн хурлын тэмдэглэл, хяналтын зөвлөл болон аудитын дүгнэлт

13.1.5.Санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан

13.1.6.Анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийн баримт бичиг

13.1.7.Бусад баримт бичиг

13.1.8.Компани нь бичиг баримтыг өөрийн үйл ажиллагаагаа эрхлэн явуулж байгаа газарт хадгална.

13.1.9.Компани нь өөрийн дүрэм, түүний нэмэлт өөрчлөлтийг байнга хадгална. Бусад баримт бичгийг холбогдох дүрэм, журам, зааврын дагуу төрийн архивт шилжүүлнэ. Компани нь жил бүр байгууллагынхаа баримт бичиг нягтлан шалгах комиссын хурлаар хэлэлцэж, аймгийн БНШАЗК-оор батлуулсан Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу баримтаа эмхлэн цэгцлэн Байнга хадгалах баримтыг Төрийн архивын сан хөмрөгт цаасан болон цахимаар өгөх, түр хадгалах баримтыг байгууллагынхаа архивт хадгална.

#### **Арван дөрөв. Компанийг татан буулгах**

14.1.Компанийг хувь нийлүүлэгчдийн хурал болон Шүүхийн шийдвэрээр татан буулгана.

14.1.2.Татан буулгах комисс томилсноор тухайн компанийн гүйцэтгэх удирдлагын бүрэн эрх дуусгавар болж, татан буулгах комисст шилжинэ.

#### **Арван тав. Бусад**

15.1.Энэ дүрэмд заасан зүйлээс бусад асуудлыг Монгол Улсын Компанийн тухай хууль болон бусад хууль тогтоомжийн дагуу зохицуулна.

\_\_\_\_\_оОо\_\_\_\_\_